

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХДУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 54 (2318) 1974 оны 7 дугаар сарын 18 ПҮРЭВ

ШИЙДВЭРЛЭХ ХАГАС ЖИЛИЙН ЗОРИЛТ

Түүхт их ойнуудыг угтсан бүх ард түмний социалист уралдаан манай аймаг даяар эрчимтэй өрнөсний үрээр V таван жилийн төлөвлөгөөг биелүүлэх суурь дэвсгэр он-1974 оны эхний хагас жилийн аж ахуй, соёлын төлөвлөгөөг зорилт амжилттай биелэгдлээ.

Манай аймгийн ажил хичээнгүй малчид 538,7 мянган төл бэйжүүлж улсын төлөвлөгөөг эхний хагас жилд 106,5 хувиар биелүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 100,3 мянгаар илүү байна.

Малын зүй бус хорогдлыг багасгах талаар аймгийн нам, улс, олон нийт ХАА-н байгууллагаас авч явуулсан арга хэмжээний дүнд том малын хорогдол өнгөрсөн оны мөн үеийнхээс 39,1 хувь, төлийн хорогдлыг 32,8 хувиар багасгалаа. Тус аймгийн тариаланчид хаврын тариалалтын ажлыг агротехникийн ашигтай хугацаанд хийж 121,6 мянган га газарт үр суулгаж төлөвлөгөөг 101,8 хувиар биелүүлэв.

1974 оны эхний хагас жилд 20,2 мянган малын багтаамжтай 61 хашаа барьж ашиглалтанд оруулсан нь энэ онд барих хашааны 51,3 хувийг эзлэж байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг 14,3 хувиар давуулан биелүүлсэн нь төлөвлөгөөнөөс 867,3 мянган төгрөгийн бүтээгдэхүүнээр илүү байна. Мөн барилга, зам, тээвэр, холбооны салбарын эхний хагас жилийн төлөвлөгөө үндсэн үзүүлэлтээрээ биелэв.

Худалдаа үйлчилгээ, ардын боловсрол соёл, эрүүлийг хамгаалах салбарынхан эхний хагас жилийн төлөвлөгөөг зорилтыг амжилттай биелүүлж ардын хувьсгалын ойг хөдөлмөрийн шинэ амжилтаар угтлаа.

Манай аймгийн аж ахуй, соёлын салбарт гарч байгаа өдгөөр ололт амжилтын зэрэгцээ зарим сум, үйлдвэр, аж ахуйн газар улсын төлөвлөгөө таслан төлөвлөгөөний сахилга батыг гажуудуулах, олсон амжилтандаа тайвширч, малын зүй бус хорогдлыг багасгаж чадахгүй, чанаргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэж гологдол гаргах, хүч чадлыг дүүрэн ашиглахгүй байх зэрэг дутагдал гаргаж байгааг арилгах хэрэгтэй. Нэгэнт олж хуримтлуулсан туршлага амжилтаа бататган МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурлын шийдвэр болон бүх ард түмний социалист уралдаанд шалгаргачдын чуулга уулзалтын уриалгыг ширхэгчлэн хэрэгжүүлж төлөвлөгөөг зорилтыг жигд хангаж, социалист уралдаанд авсан үүргээ бүрэн биелүүлэх явдал шийдвэрлэх хагас жилийн нэн чухал зорилт болж байна.

Үүний тулд нам, улс, олон нийт, ХАА-н байгууллагууд шийдвэрлэгдээгүй асуудалд онцгой анхаарал тавьж түүнд ажлын голыг чиглүүлэх нь чухал.

Ялангуяа 1974 оны мал өсгөх төлөвлөгөөг таван төрөлд нь биелүүлэн дүнгээр нь 1975 оны хэмжээнд хүргэн бод малыг илүүтэй өсгөх талаар аймгийн намын XVI бага хурлаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд зун намын улиралд малыг отроор таргалуулах, ээлтүүлгийг сайн зохион байгуулах, малын тэжээл бэлтгэх, хашаа, худаг сэлбэж засах зэрэг мал аж ахуйн өвлийн бэлтгэл ажлыг одооноос сайн хангах, малын зүй бус хорогдлыг багасгах ажлыг улам эрчимжүүлэх, үр тариа малын тэжээл, төмс, хүнсний ногоог арчлан тордох арвин ургац хураах, ХАА-н бэлтгэлийн төлөвлөгөөг ханган биелүүлэхэд онцгой анхаарах нь чухал байна. Бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, чанарыг сайжруулан, үйлчилгээний соёлч шуурхай байдлыг хангаж, төлөвлөгөөг зорилтыг чанарын бүх үзүүлэлтээр хугацааны нь өмнө биелүүлэхэд үйлдвэр аж ахуй, худалдаа үйлчилгээ ардын боловсрол, соёл эрүүлийг хамгаалах байгууллагын гол зорилт оршиж байна. Түүнчлэн хяналт шалгалтын ажлыг юуны өмнө улсын төлөвлөгөө уралдааны үүргийн биелэлтийг хангах, нийгмийн өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах хүмүүсийн хөдөлмөрийн сахилга бат, хувийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглүүлбэл зохино.

АВАРГА МАЛЧНЫ ЯРИА

Баянцагаан сумын «Өрнөх-амьдрал» нэгдлийн хоньчин улсын аварга малчин Ж. Хүрэл Хонь яаж хариулдаг арга туршлагаасаа ярьж өгнө үү гэсэн асуултанд:

—Хонийг аль ч улиралд тогтуун тууж бэлчээрт нь хүргээд тааваар нь идэшлүүлэх хэрэгтэй. Малыг ширүүн хөөж, цочоож хэрхэвч болохгүй. Малчин хүн малаа бэлчээх бэлчээрийнхээ гарц, ургамлыг сайн мэддэг байх нь чухал.

Бэлчээрээ хуваарьтайгаар ашиглах хэрэгтэй. Зарим малчид хонио бөөнөөр нь авчираад хашиж, холбоод л саадаг нь идэшлэлтэнд нь саад болдог. Одоо саалийн үе учир үүнийг анхаарах нь чухал гэж ярих.

Т. ГАВАА

Малын зүй бусын хорогдлыг багасгах талаар амжилт гаргасан ХАА-н нэгдэл, САА-н бригад, Ферм эмчилгээ, тэжээл, тэжээлийн цэг, суурь, мал аж ахуйн мэргэжилтэн, малчдыг шалгаруулах уралдааны БОЛЗОЛ 1974—6—5

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс гаргасан «Малын зүй бусын хорогдлыг багасгах арга хэмжээний тухай» 1973 оны 25 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, мал өсгөх төлөвлөгөөг давуулан биелүүлэх ажилд өндөр амжилт гаргасан бригад, ферм, эмчилгээ тэжээл, тэжээлийн цэгүүд, суурь, мал аж ахуйн мэргэжилтэн, малчдыг шалгаруулан дүгнэх болно.

НЭГ. Уралдаанд шалгаруулах үзүүлэлтүүд 1. Мал аж ахуйн бригад, ферм

—том малын зүй бусын хорогдлыг оны эхний малын 2 хувиас хэтрүүлэхгүй байх.

—оны хэнд байсан 100 хээлтэгч тутмаас бойжуулах төлийн тоо МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1972 оны 32 дугаар тогтоолд заасан хэмжээнээс доогуургүй байх.

—мал өсгөх төлөвлөгөөг таван төрөл дээр нь биелүүлэх.

—малын халдварт хамуу өвчин гаргаагүй, шинжилгээгээр ям, бруцеллэ, сүрьеэ өвчтэй гарсан малыг бүрэн ялгаж суурилан, үхрийн гуурталтыг 95-аас доошгүй хувиар багасгасан байна.

—өвчилсэн бүх малыг эмчилгээ тэжээлийн цэгт төвлөрүүлэн эмчилж, өвчнөөр суурь дээр мал үхүүлээгүй байх.

—бригад, фермийн дарга, хариуцлагатан, мэргэжилтэн нар бригад, фермийн үйлдвэрлэлийн дүнд төвлөрөн бууж үйлдвэрлэлээ байнга удирдан ажилладаг байх.

2. Эмчилгээ-тэжээлийн цэг —малын сууринд дээр өвчилсэн бүх малыг цэгт цугларуулан эмчилж, 90-ээс доошгүй хувийг эрүүлжүүлсэн байна.

Аймгийн Намын хороо

—эмчилгээ тэжээлийн цэгт ирсэн бүх малд амбулаторийн журнал өвчний түүх хөтлөн, цэгт ирсэн ба өдгөрсөн, үхсэн малын орлого зарлагын тооцоог тогтмол хөтлөж байх.

—цэгт өгөгдсөн махны төлөвлөгөөг биелүүлж үхсэн мал нэг бүрийн арвс шир, яс, тос, ноос, эвэр туурай зэрэг бүтээгдэхүүнд чанарын заслага хийж давслаг тордох зэргээр боловсруулан ашигласан байх.

—Эм хэрэглэл, тэжээлийн зарцуулалт, цэгийн машины ашиглалтанд тодорхой тооцоо хөтлөн, шахауун, засварын зардлыг хэмнэсэн байх.

—Цэгийн ариун цэвэр, шаардагдах тоног төхөөрөмж, тохижилтыг үлгэр жишээ хангаж ажиллах.

3. Тэжээлийн цэг —Бог малын цэгт 400, бод малын цэгт 200, холимог малтай цэгт бод мал 200, бог мал 100-гаас доошгүйг тогтмол тэжээсэн байх.

—Тэжээлийн цэгт ирж тэжээгдсэн мал нь дундаас доошгүй тарга хүч авсан байх.

—малд тэжээлийг тогтоосон жор, цагийн хуваарийн дагуу өгч ус, хужир, дулаан байраар хангасан байна.

—тэжээлийг аж ахуйчаар ашиглан, зарцуулалтын тооцоо, тайланг сартуулан гаргаж байх.

ХОЁР. Болзлыг дүгнэх хугацаа, журам, шагнал Болзлыг 1976 оны 1 дүгээр сард шалгаруулан дүгнэж шалгарсан бригад, ферм, эмчилгээ-тэжээл, тэжээлийн цэгүүд, суурь, мал аж ахуйн мэргэжилтэн, малчдыг аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЗ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооны диплом, мөнгөн шагнал, үнэ бүхий зүйлээр шагнана. Үүнд:

АДХ-ын гүйцэтгэх захиргаа

бригад, ферм 1 дүгээр байр 1-д 1500 төгрөг 2 дугаар байр 2-д 1000 төгрөг 3 дугаар байр 2-д 800 төгрөг

эмчилгээ-тэжээл, тэжээлийн цэг 1 дүгээр байр тус бүр 1-д 1000 төгрөг 2 дугаар байр тус бүр 2-д 800 төгрөг 3 дугаар байр тус бүр 2-д 500 төгрөг суурь

—том малын толгойн хамгаалалтыг 98 хувиас дээш байлган, оны эхний хээлтэгч малын 97-гоос доошгүй хувьд хээл авахуулж, хээлийг бүрэн хамгаалсан байна. Мөн 100 хээлтэгч тутмаас бойжуулсан төлөөр МАХН-ын Төв Хорооны 9 дүгээр бүгд хурлын шийдвэрийг биелүүлсэн суурийн малдаас (малын ашиг шинийг ашиглах талаар уралдаанд шахуу үүрэг авч түүнийг биелүүлсэн, өвөлжилт, төлийн бэлтгэл, мал оторлолт, анхан шатны бүртгэл, суурийн хүмүүжийн ажлын байдлыг харгалзан) 100 хүн шалгаруулж, мэнд сүрэгтийн гэрчилгээ, үнэмлэх, хромон гутал, толь, гөлөм, хоргой зэрэг 1000 хүртэл төгрөгийн үнэ бүхий зүйлээр шагнана.

—малын зүй бусын хорогдлыг багасгахад гарамгай амжилт гаргасан сум, бригад, фермийн удирдах ажилтан, мал аж ахуйн мэргэжилтэн, малчид, илгээлтийн эзэд, залуучуудас-шалгаруулан 3 хүнийг ЗХУ-ын Курган мужид, 10 хүнийг улсын амралтанд холбогдох байгууллагуудын зардлаар жуулчлуулах ба амруулах, мөн 50-наас доошгүй хүнийг үнэ бүхий зүйл, мөнгөн шагналаар шагнах буюу БНМАУ-ын Засгийн дээд шагналд тодорхойлно.

УЗ-ийн ХЗЭ-ийн зөвлөл хороо

Отрын бэлчээрт

Сэргэлэн сум-нэгдлийн «Авдар» бригадын бог, бодын 40 суурийн малчид Авдарын ар, Сэрүүн хүйтэн, Өөлд, Сөдтөй зэрэг сорог сөрмүүн бэлчээрт

оторт гараад байна. Сумын аварга А. Батаа, Д. Гүржав, илгээлтийн эзэн Г. Пүрэвсүрэн нар хавар 850—1600 хонийг 29 кг дундаж жинтэй хүлээн аваад 1975 оны бэлтгэлийн мал тушаалтаар 40

кг хүргэж таргалуулах үүрэг аваад оторлолтод хошуучилж явна.

Мөн Ж. Сүрэнжав зөвлөх багштай хэсэг малчид 4000 гаруй эр хургыг отроор таргалуулж байна.

Минүүд элбэг учраас но
лоон үед нь халаад ханд
хийж малд өгөхөд сайн
байдаг.

Эмн их байна Түүнчлэн
авархан хатлаг урломд-

тэсвэртэйг дараа нь хадх хэрэгтэй. Хүлээн авчар хүнд үүрвас нам доор газрын ургамлыг эмдэхэн хатаадог.

Хөдөлгөөс хадгална

Халсан өвчинтэй 15-17
хувийн чингтэй байхад
нь хураана. Басний чин-
гит олон янзаар мэдээл
агта бий бөгөөд элдэв
хэрлийн нөхцөлд хамгийн

Энгийнээр мушгиж үзээд чийгтэй нэгдэх арга байдаг. Мушгилах 90 градус дээр тасарч байна! 15-17 хувиан чийгтэй, үүнээс идүү мушгилах тасрахгүйг байвал дээрхи хэмжээнээс идүү чийгтэй байх жин шалтгай.

Л. СОДНОМДАРЖАА

договоре билгүүлсэн гэрж
пиратад эхэллээ.

цэрийн сайхан, эзэн хүний мэдлэгт шаардлагат юм. Шөнө нь манайж, хонооод, өдөр нь уснаж, хужирдаж байдал төгсөх үүс сүйн аах юм. Төгсөх үүс сүйн бөөс ангуу өвч, харын угилралд авлахгүй, харин хөөрлийг нь нарав-дан тал алах шаардлагатай

Бүх ард түмний сонголт уриалагддаг төл, ноос үс, толгой хамгаалагч талдаа б5 эмнэг сурах үүрэг авч биедүүсэн гэж яригдаа.

Р. БАЙРСАЦХАН

Биегүйлэх явдал чухал зорилт болж байна

төөр хангалтгүй дүн үзүүлэв. Эд хөрөнгийн тооллого, тоолоог үзнэв хийх өмнөд хяналт тавих, тоололын комиссын ажлыг дүнгээс зэрэг ажил зарим газруудад муу зохион байгуулгаж тооллогын цэр навуудыг бууруулсан байна.

дэгдэн, гаднаа Орлод
Эрдэнэт, Зуулдод хо-
тод нигээд хэмжээтэй
баттай нь нэрлээ. Бэлн-
ажууд сууны «Хайрхан»
нэгдлийн сэлээд бритагч
адуучин Цэрэнсодном ха-
риуцан малал бул адуу-
ныгаа 65-т хүнд тараж,
40 адуу агуулдуудыг, баал,
Бондигал, Борлуур сун-

рундатчдын тооноос 60-
доход 17—20 гаруй мян-
тан төгрөгийн дутагдах
тарсан нь нийгмийн со-
циалст өмчийн хамгаалсан
бэхжүүлэх талд ар намаас
тэвж баатга зорилттой

3-
X
M
H-
H
X
H
T-

2
 3
 4
 5
 6
 7
 8
 9
 10
 11
 12
 13
 14
 15
 16
 17
 18
 19
 20
 21
 22
 23
 24
 25
 26
 27
 28
 29
 30
 31
 32
 33
 34
 35
 36
 37
 38
 39
 40
 41
 42
 43
 44
 45
 46
 47
 48
 49
 50
 51
 52
 53
 54
 55
 56
 57
 58
 59
 60
 61
 62
 63
 64
 65
 66
 67
 68
 69
 70
 71
 72
 73
 74
 75
 76
 77
 78
 79
 80
 81
 82
 83
 84
 85
 86
 87
 88
 89
 90
 91
 92
 93
 94
 95
 96
 97
 98
 99
 100
 101
 102
 103
 104
 105
 106
 107
 108
 109
 110
 111
 112
 113
 114
 115
 116
 117
 118
 119
 120
 121
 122
 123
 124
 125
 126
 127
 128
 129
 130
 131
 132
 133
 134
 135
 136
 137
 138
 139
 140
 141
 142
 143
 144
 145
 146
 147
 148
 149
 150
 151
 152
 153
 154
 155
 156
 157
 158
 159
 160
 161
 162
 163
 164
 165
 166
 167
 168
 169
 170
 171
 172
 173
 174
 175
 176
 177
 178
 179
 180
 181
 182
 183
 184
 185
 186
 187
 188
 189
 190
 191
 192
 193
 194
 195
 196
 197
 198
 199
 200
 201
 202
 203
 204
 205
 206
 207
 208
 209
 210
 211
 212
 213
 214
 215
 216
 217
 218
 219
 220
 221
 222
 223
 224
 225
 226
 227
 228
 229
 230
 231
 232
 233
 234
 235
 236
 237
 238
 239
 240
 241
 242
 243
 244
 245
 246
 247
 248
 249
 250
 251
 252
 253
 254
 255
 256
 257
 258
 259
 260
 261
 262
 263
 264
 265
 266
 267
 268
 269
 270
 271
 272
 273
 274
 275
 276
 277
 278
 279
 280
 281
 282
 283
 284
 285
 286
 287
 288
 289
 290
 291
 292
 293
 294
 295
 296
 297
 298
 299
 300
 301
 302
 303
 304
 305
 306
 307
 308
 309
 310
 311
 312
 313
 314
 315
 316
 317
 318
 319
 320
 321
 322
 323
 324
 325
 326
 327
 328
 329
 330
 331
 332
 333
 334
 335
 336
 337
 338
 339
 340
 341
 342
 343
 344
 345
 346
 347
 348
 349
 350
 351
 352
 353
 354
 355
 356
 357
 358
 359
 360
 361
 362
 363
 364
 365
 366
 367
 368
 369
 370
 371
 372
 373
 374
 375
 376
 377
 378
 379
 380
 381
 382
 383
 384
 385
 386
 387
 388
 389
 390
 391
 392
 393
 394
 395
 396
 397
 398
 399
 400
 401
 402
 403
 404
 405
 406
 407
 408
 409
 410
 411
 412
 413
 414
 415
 416
 417
 418
 419
 420
 421
 422
 423
 424
 425
 426
 427
 428
 429
 430
 431
 432
 433
 434
 435
 436
 437
 438
 439
 440
 441
 442
 443
 444
 445
 446
 447
 448
 449
 450
 451
 452
 453
 454
 455
 456
 457
 458
 459
 460
 461
 462
 463
 464
 465
 466
 467
 468
 469
 470
 471
 472
 473
 474
 475
 476
 477
 478
 479
 480
 481
 482
 483
 484
 485
 486
 487
 488
 489
 490
 491
 492
 493
 494
 495
 496
 497
 498
 499
 500
 501
 502
 503
 504
 505
 506
 507
 508
 509
 510
 511
 512
 513
 514
 515
 516
 517
 518
 519
 520
 521
 522
 523
 524
 525
 526

This image shows a blank, aged, cream-colored page, likely an endpaper or flyleaf from an old book. The paper has a slightly textured appearance with some minor discoloration and wear. There are two small, circular holes near the top edge, possibly from a binding process. A faint, dark, irregular mark is visible near the bottom center of the page.

БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойд

МОНГОЛ ҮНДЭСТЭН ТӨЛӨВШИН ТОГТСОН НЬ

Олон үндэстэн ястны орон ЗСБНХУ болон социалист нилээд орны ард түмэн капиталист нийгмийн харилцааг устгасны үр дүнд социалист үндэстэн буй болсон билээ.

Харин капиталист хөгжлийн шатыг алгассан манай орны хувьд социалист үндэстэн бүрэлдэн тогтох асуудал өвөрмөц онцлогтой байв.

Тухайлбал олон үндэстний ЗСБНХУ байгуулагдан амжилттай хөгжсөн явдал манай оронд үндэстний асуудлыг зөв шийдвэрлэхэд үндсэн нөхцөл болж МАХН, Лениний сургаалыг мөрдлөг болгон ЗХУ-ын баялаг туршлагад түшиглэн өөрийн оронд үндэстний асуудлыг шийдвэрлэх таларх Ленин тууштай бодлогыг явуулсан юм.

1921 онд ардын хувьсгалын үр дүнд хөдөлмөрийн ардын хувьсгалт ардчилсан диктатур тогтож, феодалын ноёрхлыг үндсээр нь устгав.

Энэ үеэс социалист эдийн засгийг шинээр байгуулах, үндэстний ажилчин ангийг бий болгох, улс үндэстнийхээ соёлын хоцрогдол, бичиг үл мэдэх явдалыг арилгах зэрэг шат дараалсан ажлыг хэрэгжүүлэхэд хөгжингүй социалист үндэстний ард түмний ах дүүгийн сэтгэл харамгүй тусламж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж, хувьсгалын ардчилсан шатанд бутархай байдлыг арилгах, гадаадын капиталын эрхшээлээс ангижруулах, үндэс-

ний ажилчин анги төрж бойжив. Хувьсгалын социалист шатанд нийгэм эдийн засгийн байгууллагыг социалист ёсоор өөрчлөн 1969 онд ХАА-г хоршоолж нэгдэлжих хөдөлгөөн ялсны үр дүнд манай оронд социалист үйлдвэрлэлийн харилцаа ялсан юм.

Энэ нь монгол үндэстэн бүрэлдэн тогтох эдийн засгийн үндэс байлаа.

Тус улсын үндсэн хуульд БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа бүх үндэстэнд үндэстний соёлыг хөгжүүлэн төрөлх хэлээрээ суралцах, ажил хэргээ явуулах бололцоог улсаас олгоно гэж заажээ. Энэ ч урвас хувьсгалын жилүүдэд шинэ бичиг үсэгтэй болж халх аялгуунд түшиглэсэн монгол үндэстний нэгдмэл хэл, үндэстний хэлбэртэй социалист агуулгатай үндэстний шинэ соёл төлөвшин дэлхийн дэвшилт соёлын салшгүй нэг хэсэг боллоо.

БНМАУ-ын хүн амын 90 гаруй хувь нь халхчууд боловч монголын ард түмэн нь нэг хэл түүх соёлотой олон ястнаас бүрдэл болдог.

Олон ястны үе улирсан салангид бөглүү амьдрал нийгмийн хөгжлийн түүхэн явцад арилж янз бүрийн аялгуугаар ярьдаг олон ястан халх аялгуунд шилжиж халх аялгуу нь монгол үндэстний хэл болж байна.

Манай намаас үндэстний асуудлыг зөв шийдвэрлэхийн тулд Баянөлгийг ай-

магт казак, урианхай хэл дээр хичээл зааж, сонин сэтгүүл ном хэвлэл гаргаж байгаагийн үр дүнд эдгээр ястны дотроос эрдэмтэн төрийн зүтгэлтэн улс ардын аж ахуйн салбарын төрөл бүрийн мэргэжилтнүүд олширсор байгаа юм.

Мөн манай оронд улс төр эдийн засаг, ёс суртахуун оюун санааны бат зузаан нэгдэл бий болсон нь монголын янз бүрийн ястан аажмаар ойртож нэгдэн, түүхэн богино хугацаанд социалист монгол үндэстэн төлөвшин тогтлоо.

Манай социалист улс хүнийг ямар ястан гэдгээр үнэлдэггүй гагцхүү улс эх орныхоо тусын тулд цуцалтгүй хөдөлмөрдөгөөр нь улс орныхоо өмнө хүлээсэн эх оронч үүргээ хир зэрэг биелүүлж ойлгодгоор үнэлдэг. Үүний үрээр манай ард түмний эв нэгдэл өдөр бүр бэхжиж яс үндсээр ялгаварлан гадуурхах, үндсэрхүү үзэл арилан найдвартай социалист орон боллоо.

Капитализмын өмнөх харьцаанаас социализмд шилжих замд хөгжингүй социалист үндэстний зүгээс үзүүлэх интернационалист тусламж зайлшгүй болохыг харуулж феодализмын үеийн ястнаас үндэстний хөгжлийн капиталист шатыг алгасан социалист үндэстэн төлөвшилтийг манай улсын түүхэн туршлага харуулж байгаа юм.

А. ЖАМБАЛДОРЖ

КОММУНИЗМЫН ОРНЫ АЛХАА

ЗХУ-ЫН АВТОМАШИНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ

ЗХУКН-ын XXIV их хурлаас батласан ЗСБНХУ-ын улс ардын аж ахуйг 1971—1975 онд хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөний удирдамжинд 1975 онд автомашины үйлдвэрлэлийг 2—21 саяд хүргэх, үүний дотор ачааны машины үйлдвэрлэлийг 1,5 дахин суудлын автомашиныг 3,5—3,8 дахин нэмэгдүүлэхээр заасан байна.

Одоо ЗХУ дэлхийн 75 оронд автомашин, 59 оронд экскаватор, бульдозер, автогрейдер, гинжит дугуйт өргөгч цамхаг нийлүүлж, гадаадын 200 гаруй пүүз байгууллагатай худалдаа хийж байна.

Зөвлөлтийн автомашиныг социалист орнууд хамгийн олноор авдаг.

Тухайлбал ЗХУ-аас БНМАУ-д авто өргөгч экскаватор, зуурмагийн шахуур, бетон холигч, цемент зөөгч автомашин, авто ачигч, суваг ухагч, түймэр унтраах зэрэг зам барилгын техник болон бусад олон нэр төрлийн машин техникийг нийлүүлж байна.

ЭХТЗ-ийн XXV чуулганаас батласан цогцолбор программын дагуу социалист олонхи орны авто тээврийн хэрэгцээний үлэмж хэсгийг ЗХУ-аас нийлүүлэх автомашинаар хангах болно.

Автомашин үйлдвэр

рийн яамнаас 1971—1975 онд ачааны автомашины ба авто чиргүүлийн 22 шинэ загварын үйлдвэрлэлийг эзэмшихээр төлөвлөж байна. Энэ хугацаанд жилдээ дизель мотортой 150 мянган автомашин гаргаж чадах Камын автомашины иж бүрэн завод байгуулахаар төлөвлөжээ. Жилдээ 660 мянган суудлын автомашины үйлдвэрлэх чадалтай Волгын автомашиныг заводыг барьж дуусгаад хүчин чадалыг нь бүрэн ашиглах болно. ЗХУ-д ачааны машин, ялангуяа их даацтай автомашины үйлдвэрлэл нэмэгдэв.

Тухайлбал: И. Х. Лихачевын нэрэмжит Москвын болон Минскийн автомашины завод нь дунд зэргийн даацтай автомашины гол загварын үйлдвэрлэлийг өргөтгөхийн зэрэгцээ их даацтай гурван голтой шинэ маягийн автомашиныг үйлдвэрлэх бөгөөд тэдгээр машин нь чиргүүлийн хамт 14—25 тонн ачаа тээвэрлэж чадах юм.

Ингэж ЗХУ-ын автомашины үйлдвэрлэл нь өөрийнхөө хөгжилд орчин үеийн шинжлэх ухаан техникийн сүүлийн үеийн ололгод тулгуурлаж байна.

Инженер С. ТҮВДЭНДОРЖ

НЯРАВ БАГА ЭМЧ

Ш. Дондов тэжээлийн фондын улсын конторын нярав бага эмчээр 1969 оноос хойш тасралтгүй ажиллажээ. Тэрээр 16 нэгдэл, 5 САА, үржил зохиомол хээлтүүлэгийн улсын станц болон мал аж ахуйтай албан үйлдвэрийн газруудад хөнгөн шуурхай үйлчилж олны талархлыг байнга хүлээж байна.

Нярав Дондов 1972 онд СХТБ-д орж гавшгайч болсон бөгөөд эм бараа татах авах 1971—1973 оны төлөвлөгөөг 156,6—174,4, борлуулалтын төлөвлөгөөг 108,5—147,2 хувь, 1974 оны 1 дүгээр улирлын бараа татан авалтыг 167,8, борлуулалтыг 118,4 хувиар биелүүлэн конторын ажилчдын дунд зарласан 1000 баллын уралдаанд хошуучилж явна.

Няраваар ажиллаж байгаа хугацаандаа дутагдал шамшигдал гаргалгүй ажиллаж сүүлийн таван жилд улсад 10 гаруй мянган төгрөгийн, байгууллагадаа 3 мянган төгрөгийн хуримтлал оруулжээ.

Нярав Ш. Дондов эм багаж, тарилга туулгын эм, үр зэргийг юуны өм-

но нарийн нягт хүлээн аваад дор нь ярилч бичин складын бүртгэлд авч төрөлжүүлэн хурааж эм барааны орлого зарлагын хөдөлгөөнийг гарсан цаг тухайд нь хөтөлж үлдэгдлийг гарган бэлэн үлдэгдэл бараатай нь байнга тулган шалгадаг юм.

Складын зориулалттай биш байшингийн жижиг тасалгаануудын талбайг ванзан тавиур ханын шкаф хийж ашиглажээ.

Өөрийн хариуцаж байгаа эм багажийн зориулалт хэрхэн хэрэглэж ашиглах түүний ашиг тус хугацаа, нормыг өөрөө сайн мэдэж худалдан авагч бүрт тайлбарлан таниулж биет үзүүлэн самбараар сурталчлах зэргээр борлуулалт хийдгээс гад үйлдлийн төлөвлөгөөг байнга давуулан биелүүлдэг байна.

Мөн анхан шатны бүртгэлийг бүрэн чанартай хөтөлж, тооцоог сайн хийдгээс сар улирал жилийн тооллого явуулах тооцоо бодох ажлыг эрс хөнгөвчилдэг юм.

Д. НОРОЛХОО

БАСОВЫН ТУРШЛАГААР АЖИЛЛАЦГАА

ЗХУ-ын социалист хөдөлмөрийн баатар А. Д. Басов Москва хотын барилгын 26 дугаар трестийн бригадын даргаар ажилладаг. Эдний бригад хөдөлмөрийн сахилга бат болон аюулгүй ажиллах арга барилын талаар өчүүхэн ч зөрчил гаргахгүй байх үүрэг аваад сүүлийн 18 жил үйлдвэрлэлтэй холбогдсон осол гэмтэлгүй ажиллаж байна.

Осол гэмтэлгүй ажиллахын нэг гол хөшүүрэг нь ажилчин бүр хөдөлмөрийн сахилга батыг чанд сахих явдал юм.

Иймээс юуны өмнө ажилчдын аюулгүй ажиллах арга барилын мэдлэгийг дээшлүүлэн, тэднийг аюулгүй ажиллагааны арга барил үйлдвэрлэлийн аруун цэвэр, эрүүл ахуйн норм дүрмийг ширхэгчлэн биелүүлдэг болгон хүмүүжүүлэх ажлыг хүчтэй зохиох, өөрийн мэдлэг чаддаг зүйлээ нөхөлдөө зааж сургадаг заншилтай болгох талаар А. Д. Басов онцгой анхаарч ажилладаг ажээ.

А. Д. Басов өдөр бүр ажил эхлэхийн өмнө хө-

дөлмөр хамгааллын олон нийтийн байцаагчийн хамт ажлын байраар явж үзлэг шалгалт хийдэг бөгөөд үзлэгийн дараа бригадын хүмүүст хийх ажлын чиглэлийг хэлж, аюул осолгүй ажиллахын тулд юуг анхаарвал зохих тухай тодорхой тайлбарлаж өгдөг байна.

Барилгын удирдах газрын аль нэг трест, контор, анги салбарт гарсан ослын тухай ажилчдад сонсгон, тэр ослын шалтгаан болон урьдчилан сэргийлэх амар арга хэмжээнүүдийг авсан бол уул осол гарахгүй байх боломжтой байсныг нарийвчлан ярьж өгдөг болжээ.

Үйлдвэрлэлийн осол гэмтэлгүй ажиллуулах талаар авч байгаа цаашдаг авахаар төлөвлөж байгаа арга хэмжээнүүдийн тухай ерөнхий инженер бүх ажилчдын хуралд сонсголт тавьдаг заншилтай болсон байна.

Энэ хурал дээр ажилчин бүр өөрийн санал хүсэлтээ тавьдаг аж.

Осол гэмтэлгүй ажиллахын бас нэг гол үндэс

бол 3 шатны үзлэгийг тогтмолжуулан чанаржуулах явдал гэж А. Д. Басов үздэг.

Нэгдүгээр шатны үзлэгийг бригадын дарга, олон нийтийн байцаагчтай хамт ран өдөр бүр ажил эхлэхийн өмнө хийнэ.

Хоёрдугаар шатны үзлэгийг анги салбар хэсгийн дарга нар хөдөлмөр хамгааллын комиссын гишүүдтэй хамтран долоо хоногт нэг удаа хийнэ.

Гуравдугаар шатны үзлэгийг ерөнхий инженер, ҮЭ-ийн хорооны даргын хамт сард 1 удаа хийнэ.

Энэ үзлэгүүдээр илэрсэн дутагдлыг бригад нэг бүрт хөтөлгөж байдаг үзлэгийн дэвтэрт бичдэг ба түүний дагуу зохих арга хэмжээг авдаг байна.

А. Д. Басовын бригад нь ахуй үйлчилгээгээр бүрэн хангагдсан бөгөөд хөдөлмөр хамгааллын булан байгуулан аюулгүй ажиллагааны арга барилын сургалтын ажлыг явуулах төв болгон ашиглаж байна.

Ш. БАТТУЛГА



Зуунмод хотын нэгдсэн больницны мэс заслын тасгийн асрагч Дэжид хөнгөн шуурхай үйлчилгээгээрээ олны талархал хүлээж байна.

Тэрээр тасгийнхаа цэвэрлэгээг чанартай сайн хийдгээс түүний хариуцсан тасаг үргэлж цэвэр цэмцгэр байдаг ажээ.

Т. ДАШНЯМ-ын авсан гэрэл зураг

Тунхагласнынь 30 жилийн ойд

ӨНӨӨГИЙН ПОЛЬШ ОРОН

1974 оны 7 дугаар сарын 22-нд БНПАУ фашистын дарлалаас чөлөөлөгдсөнийхээ гурулдарт 30 жилийн ойг ах дүү социалист орнуудын хамт ёслол төгөлдөр тэмдэглэх гэж байна.

Гучин жилийн тэртээ үндэсний чөлөөлөх польшийн хороо, хараат биш ардчилсан Польшийн байгуулалтын программын үндсийг тавьсан 7 дугаар сарын түүхт тунхагаа гаргажээ. БНПАУ нь төв Европод оршиж 312,7 мянган хавтгай дөрвөлжин км дэвсгэр нутаг, 33,2 сая хүн амтай орон юм.

Ардын засгийн үед хүн ам нь 10 саяар өсч хүн амаараа Европод 7 дугаар байр эзэлдэг юм. Хүн амын 37 хувь нь 19 нас хүрээгүй хүмүүс учир Польшийг залуусын орон гэдэг. БНПАУ-ын үндэсний орлого нь асар өндөр хурдацтай өсч байгаагийн үрээр хүн амд ноогдож байгаа үндэсний

орлого нь 1938 оныхтой зэрэгцүүлэхэд бараг 7 дахин өсчээ. БНПАУ нь машины үйлдвэрийн хүчирхэг баазтай болсны гадна улс орныхоо бүх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 28 хувийг экспортод гаргаж байна.

Тус оронд химийн аж үйлдвэр, эмийн бараа, чулуун нүүрс болон хүрэн нүүрс олзворлолт онцгой түргэн хөгжиж байна.

Дайнаас хойш байгуулагдсан шинэчлэгдсэн үйлдвэрүүдээс гаргаж байгаа нийт бүтээгдэхүүн 1938 оныхтой зэрэгцүүлвэл 20 дахин өсч Польш улс энэ үзүүлэлтээрээ дэлхийд арав, Европод зургадугаар байранд тус тус оржээ.

Эрчим хүч асар өндөр хурдацтай хөгжиж таван жилийн эцэст жилд 100 орчим миллиард цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх болно. 1950 оныг 1973 онтой харьцуулвал аж үйлдвэрийн үйлдвэр-

лэл 9,5 дахин өссөний гадна хөлөг онгоц үйлдвэрлэх хүчирхэг үйлдвэртэй болсон явдал нь Польшийн чухал ололт юм.

20 гаруй жилийн дотор далайн 1175 хөлөг онгоцыг тоноглож түүнийхээ 900 гаруйг гадаад оронд нийлүүлжээ.

Далайн хөлөг онгоц гадаадад гаргадгаараа дэлхийд VIII байранд орж байна. Сүүлийн 23 жилд Польшийн ХАА-н үйлдвэрлэл 1,9 дахин өссөний гадна тариалангийнх нь талбайд 300,0 мянган трактор болон ХАА-н өндөр бүтээлтэй машин техник тоног төхөөрөмж ажиллаж байна.

Сүүлийн дөрвөн жилд 20 гаруй мянган га талбайд жимс жимсгэнэ тариалж жимс хүнсний ногооны талбайг нилээд өргөтгөжээ.

1973 онд үйлдвэрлэн гаргасан ХАА-н бүтээгдэхүүн нь дайны өмнөхөөс 2 дахин их болжээ.

Польшийн «Пионер» заводод төмс хураагч орчин үеийн загварын комбайн үйлдвэрлэж байгаа бөгөөд цаашид жил тутам төмс хураагч ийм комбайн 5,0 мянгын үйлдвэрлэх юм. 1956 оноос эхлэн хотод 2,5 сая, хөдөөд сая шахам сууц барьжээ.

Польш ард улсад хөдөлмөрчдийн амьдралын нөхцөл улам сайжирч нолдингсоос эмнэлгийн үйлчилгээг үнэ төлбөргүй болгож 1938 онд 70,0 мянган хүн дээд боловсролын дипломтой байсан бол 1973 онд 740,0 гаруй мянган хүн болж 4,0 сая орчим хүн ерөнхий боловсролын дунд, техник мэргэжлийн боловсролтой болжээ. Сүүлийн 3 жилийн туршид бодит цалин дундаар 25 хувиар нэмэгдэв.

БНПАУ 100 дээд сургуультай байгаагийн 70 орчим нь ардын засгийн жилд байгуулагджээ.

БНПАУ-д 350 орчим мянган оюутан суралцаж байна. Дайны дараах 26 жилд эмч нарын тоо 7 дахин нэмэгдэж одоо 45,6 мянган эмч нар ажиллаж байна. Н. ХАНДСҮРЭН

Ариун цэврийн сарын ажилд ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХҮЙ

Гэдэсний халдварт өвчин үүсгэгч нян, цагаан хорхойн өндгөөр бохирлогдсон газрын хөрс нь янз бүрийн өвчнийг тараах аюултай учир хөрснийг бохирдлоос хамгаалах нь чухал юм. Хөрс нь хүний өтгөн шингэн ялгадас хог хаягдал угаадаас зэргээр бохирлогдох тул тэдгээрийг хашаа гудамж талбайд ил задгай асгах явдлыг хүн бүр цээрлэх хэрэгтэй.

Харин хуурай хог хаягдал битүү таглаатай саванд цуглуулан авч ариутгаж богино хугацаанд зөөх нь чухал байдаг.

Орон нутагт хог хаягдал, бохир усыг дараах байдлаар даршилж асгана. Үүнд: Бохир ус асгаахаар сонгогч авсан газартаа өргөн нь 2—3 метр, гүн нь 15—20 см уртыг нь газрын хэмжээний байдалд тохируулан тогтоож нүх ухан түүндээ үнс үртэс сүрэл шорооны холимог зэргээр 15—20 см зузаан шавар дэвсгэр шал хийнэ. Түүн дээрээ асгах хогоо 15—20 см зузаан хэмжээтэй асган дахин шавар давхаргаар хучна.

Ийм янзаар ээлжлэн давхарлааар 1,5—2 метр өндөр болтол нь овоолно.

Овоолсон хогоо хатаах, мөн түүн дээр ялаа суухаас хамгаалж хажуу талаас нь шороогоор хучна. Ингэж дарах зүйлд гэрийн хог, идэшний ногооны навч иш зэрэг хаягдлыг хийж болно.

Жилийн турш ялангуяа зуны цагт даршилсан хо-

гонд гэдэсний өвчний нян, цагаан хорхойн өндөг үхэж сөнөдөг.

Ялаа цугларах, муухай үнэр гарахаас сэргийлж даршлан овоолж байгаа хогон дээр дулаан цагт үртэс шороо сүрлээр дарж ариутгалын бодисоор ариутгавал зохино.

Түүнчилэн хөрсний эрүүл ахуйн шаардлагыг биелүүлэхэд бие засах газар бохир усны цооногийг зөв барьж байгуулах нь чухал. Бие засах газар, бохир усны цооног нь шингэн зүйл газрын хөрсөнд орж шингэхээргүй байхаар цемент, шавар, банз, сургаагаар доторлосон байх ёстой.

Бие засах газрын их бие, хаалга, суурины хэсгээр ялаа орох зайгүй хаалга нь сайн хаагддаг байх ба цонх салхижуулалт яндантай хийнэ.

Мөн ар талд нь цэвэрлэхэд зориулагдсан нүхийг гарган битүү тагтай гаар бэлтгэнэ.

Бие засах газрын амсрын эргэн тойронд 1,5 метрээс доошгүй зайнд цардан хатуулж дотогш налуу ховил хийнэ.

Энэ нь ялааны авгалдай үржихээс сэргийлнэ. Бие засах газрын гүн нь 190 см, өргөн нь 200 см, урт нь 230—300 см багтаамж нь 6—9 куб метр байна.

Бохир усны цооногийн гүн нь 2—5 метр, өргөн нь 2 метр, урт нь 2—4 метр, багтаамж нь 8—12 куб метр байх ёстой.

Их эмч Н. ХОРОЛСҮРЭН

СУЛЬДАА ӨВЧНӨӨС ЯАЖ СЭРГИЙЛЭХ ВЭ!

Сутьдаа өвчин бага насны хүүхдэд 2—3 сартайгаас нь эхлэн тохиолддог. Сутьдаагийн үүсэх үндэс нь Витамин «Д»-ийн дутагдалтай холбогдон эрдсийн солицоонд өөрчлөлт гарна.

Сутьдаагийн эхлэх анхны шинж тэмдэг нь хүүхэд уцаар ууртай тайван бус уйламтгай их цочимтгой болно. Мөн хөлрөх, үргэлж шилээ шөргөөснөөс толгойн дагзны хэсгийн үс халцрах зэрэг байдал үзэгдэнэ.

Сутьдаа нь хүүхдийн биеийн эсжилтийг саатуулан биеийн хэлбэр дүрсний өөрчлөх, улмаар дотоод эрхтнүүдийн үйл ажиллагаанд хор хүргэнэ.

Сутьдаагаар өвчилснөөс хүүхдэд өвчлөмтгий болж хүндэрдэг. Сутьдаагаас урьдчилан сэргийлж чадвал өвчлөхгүй байж болно. Урьдчилан сэргийлэлтийг жирэмсний үеэс эхлэн эхчүүд өөрсдөө хооллох, амрах ажиллах дэглэмийг зөв баримтлан эхний ба сүүлийн саруудад витамин «Д» бусад витаминг эмчийн зааснаар хэрэглэх нь чухал.

Цай уух зуур

Одоо дэлхий дахины хэмжээгээр 300 загварын 218 сая суудлын автомашин байгаа ба эрдэмтэн нарын хийсэн тооцоогоор 2000 он гэхэд суудлын автомашинны тоо 400—600 сая болох ажээ.

1900 онд дэлхийн улс орон 5 мянгангаар автомашин үйлдвэрлэж байсан бол

Жирэмсний хүндрэлийг тууштай эмчлүүлэх, жирэмсний хугацаанд зөвлөлгөө өгөх газрын хяналтанд тогтмол байх нь ашигтай. Төрсний дараа хүүхдээ аль болохоор эхийн сүүгээр хооловчлол сайн. Төрсний дараа хүүхдэд сальдаагаас сэргийлэхээр доорхи дэглэмийг хэвшүүлэх шаардлагатай.

Үүнд: 1,5—2 сартайгаас нь хүүхдэд жимс ногооны шүүс, эхний 3 өдөр 4—5 дуслаар өдөрт 1 удаа цаашдаа 3 удаа болгон аажмаар дуслын тоог ихэсгэн, цайны халбагаар өдөрт 3 удаа, 3 сартайд нь хоолны халбагаар 3 удаа хэрэглэнэ.

Хүүхдээ угждаг бол нэмэгдэл хоолыг 4,5 сартайгаас, хөхний хүүхдэд 5 сараас нь эмчийн зөвлөгөөнөөр цагийн нарийн дэглэм баримтлан өгнө.

Сар тутамд хоолны хольц хэмжээг чанарыг эмчийн зөвлөгөөнөөр өөрчилж байх нь чухал. Хүүхдийг салхинд гаргах, зуны улиралд 7 хоног, өвөлд 3—4, 7 хоногтойгоос гадна орчны

дулаан 10—12 градусаас дээш байх ба салхи багатай намуун өдөр эрүүл агаарт гаргана.

Хүүхдийг 14 хоногт 1 удаа эхний үед 36,5 градусаас 36 градусын бүлээн усанд оруулан цаашид 1 градусаар бууруулан 35 градусаас 33 градусын усанд угаана.

Хүүхдийг 14 хоногийн өмнөөс хуурай арчилт хийж биеийн нь дасгаад 36,5 градусаас 36 градусын бүлээн усаар 3 сартайгаас нь хүүхдийн 2 гар дээд мөчийг дараа нь 2 хөл доод мөч цаашид бие нурууг арчих зэргээр дасган арчина.

Энгийн илгээлийг 2—5 сартайгаас нь эхлэн хөл гар үс мөч хэвлий ууц нуруугаар нь тогтмол хийж өгнө.

Витамин «Д»-ээр баялаг өндөгний шар, цөцгий, ургамал, загасны тосыг дуслаар 2 сартайгаас эхлэн уулгана.

Хэт ягаан туяагаар шахах, витамин «Д»-г уухад эмчийн зөвлөлгөө хэрэглэнэ.

Хүүхдийн их эмч Д. СЭМХЭЭ

зөвхөн 1972 онд 28 сая авто машин үйлдвэрлэсэн байна. Эдүгээ дэлхийн 1000 хүн ам тутамд 60 суудлын авто машин ноогдож байгаагийн дотор хөгжингүй орнуудад 1000 хүнд 200 суудлын машин оногдож байгаа аж. Хөгжингүй капита-

лист орнуудад суудлын авто машины 98 хувь нь хувийн өмчийн байдалтай байдаг байна.

ЗХУ-д эдүгээ 500 мянга илүү дэлгүүр ажиллаж бараа таваарын 40 орчим хувийг өөрөө өөртөө үйлдэх хэлбэрээр худалдаж байна.

Б. ЦЭРЭНДАШ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ